



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/164

Хэрлэн сум

Хүндэтгэл үзүүлж,
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн харьяат ахмад химийн багш Дугарын Намсрай нь Монгол Улсын гавьяат багш цол тэмдгээр шагнагдсан тул хүндэтгэл үзүүлж 430.000 (дөрвөн зуун гучин мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010447

Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 30 өдрийн
А/164 захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

| № | Зардлын нэр | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт дүн |
|---|-------------|---------------|-------------|----------|
| 1 | Мөнгөн аяга | 1 | 350.000 | 350.000 |
| 2 | Ааруул | 1кг | 20.000 | 20.000 |
| 3 | Хүндэтгэл | 1 | 60.000 | 60.000 |
| | Дүн | | | 430.000 |